

ТЭМЦЛИЙН ТУХАЙД

Д.Хүүхэнбаатар

Монгол улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх ухааны сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Хэт зүүн коммунист нам, төр засгийн бодлогыг монголын малчид, нийгмийн бусад хүчний зүгээс эсэргүүцсэн тэмцлийн асуудал, ангичлах бодлогын өрөөсгөл талыг гарган тавьсан байна.

Түлхүүр үг: Ангичлах, ажилчин, малчин ардын холбоо.

Ном зохиол судалгаанд монголын малчдын тэмцлийн гол хэлбэр нь заргын тэмцэл гэж үзэж дүгнэсэн байдаг. “Нохойтой өстэй хүн хормойгүй, Ноёнттой өстэй хүн хонгогүй” гэсэн цэцэн үг түүхийн асар их судалгааны хэрэглүүн байна. Монголчууд бол хатан зоригтой ард түмэн. Манжийн бодлогод үл автан үндсээ хаацайлж чадсан юм. XX зууны эхээр ипериализмын колончлол хүчтэй болж ирсэнээс түүнийг эсэргүүцсэн тэмцэл гарч эхэлсэн нь аргагүй юм. Октябрийн социалист хувьсгал 1917 онд мандаж, дэлхий дахинаа дорно газар колонийн хувьсгалын шинэ үе өрнөлөө.

Дорно зүгийн улс орнууд өндийн “босч” газар сайгүй тэмцэл эрч хүчээ авлаа. Энэ хувьсгалт тэмцэл юуны өмнө улс орныхоо бүрэн тусгаар тогтнол үндэсний төрөө тогтооход чиглэж байв. Түүний хамт капитализмын эдийн засгийн шунахай мөлжлөгийг таслан зогсоож, гадаадын капиталыг шахан зайлуулах тэмцэл өргөн хүрээг хамрах болжээ. Энэ их үйл явдал Азийн цээжинд хоёр гүрний хаяа дэрлэн байхад нийтийн тэмцэл өрнөж байлаа. Заргын тэмцлийг идэвхгүй хэлбэр гэх санаа байдаг. Харин феодал, ноёдыг, ихэс дээдсийг бүх л нийгмээр нь донсолгож байсан хүчин зүйл байлаа. Зарга шүүдэггүй өдөр энэ үеийн Монголд байсан юм уу.

Засагт хан аймгийн Мань гүний хошуунд Ард Аюушийн хөдөлгөөн (1903-1917) тэмцэл гарч, ардын тэмцлийн төрөл бүрийн зарга бичих, оргох зугатах дүрвэж нүүх, тэр ч байтугай мэс хэрэглэсэн тусгай баг цэрэгтэй гэх зэргээр олон тэмцлийн шинжийг агуулсан хурц тэмцэл гарсан нь санамсаргүй зүйл байсангүй. Ард Аюуш Мань гүний эсрэг заргын тэмцэл хийсэн бөгөөд ажиглахад хятад худалдаачны пүүсийг түйвээсэн нь гадаадын мөлжлөгийн эсрэг шинжтэй содон харагдана. Үүнийг дэмжсэн хөдөлгөөн гарсангүй. Сажрайдоржийн хошууны зарга ч тусдаа. Өргөн газар нутаг, тархай бутархай, холбоо харилцаа муутай нөхцөл нэгдэх бололцоог олгодоггүйг хэлэх хэрэгтэй юм. Аюуш ардын тэмцлийн шинэ хэлбэр дугуйлангийн зохион байгуулалттай гарч ирсэн. Ийм уур амьсгаат тэмцэл хөдөлгөөн эцсийн дүнд 1911-1912 оны

үндэсний эрх чөлөөний хувьсгалд хүргэсэн юм. Энэ тэмцэл манжийн эсрэг шинж нь хятадын эсрэг тусгаар тогтнолоо олохын төлөө тэмцэл болон хувирчээ.

Үндэсний хувьсгалт хөдөлгөөн ялалтанд хүрдэггүй боловч тэр их хурсан хүчин үргэлжилсээр байсан бөгөөд шинэ шатанд хүрч тэсрэлт болов. Энэ нь 1921 оны империализм эсэргүүцсэн хувьсгал болж ялалтанд хүрч мандлаа.

Ардын хувьсгалаар зөрчил тэмцэл ямар болов. Ард түмэн малчин ард хэт зүүний төр засгийг эсэргүүцэж, төр засгаа, ардын хувьсгалаа эсэргүүцэж эхэлсэн байна. Улс төрийн хүрээнд Бодоо, Данзангийн эсэргүү, баруун гэгч хөрөнгөлөг үндэсний өөрийн эдийн засгаа хөгжүүлэх этгээд гэгчид хөрөнгөтний үзэлтэй хувьсгалын эсэргүү хэмээн дайсанд үзэж ялалжээ. Баруунтны алдааг “засах” нэрийдлээр зүүний нугалаа хэмээх солиорол гарч социализм, ардын хоршоололыг кампаничлан байгуулж Оросууд Монгол оронд аймшигт нугалаа хийжээ. Бүх юм уруугаа эргэж, баларч сөнөхөд хүрлээ. Тэсэхийн аргагүй энэ гамшгийн эсрэг 1932 онд баруун дөрвөн аймагт бослого гарч ардууд хилд даван нүүх боллоо. Энэ нь тэр үеийн хэт зүүнтний төр засгийг малчид эсэргүүцэн босож ирсэн хэрэг.

Аймшигт ав хомрого, аллага хядлага, “Лхүмбийн хэрэг” гэгч Гэндэнгийн санаачилсан аллагаас үүдэн гарлаа. Эхлээд Лхүмбийн талын этгээд гэж барьж тамлан хороох боллоо. Гэвч удсангүй энэ нь “хувьсгалын эсэргүү” гэдэг нэрийн дор гаарлаа. Үүний эсрэг тэмцэл гарч байсан юм болов уу. Миний ажигласнаар хэд хэдэн баримтад Амарт танилцуулахаар оруулахад “энэ манай хүн” гэж нэг бус удаа хэлсэн байх бөгөөд би Амараар удирдуулсан эсрэг хүчин байжээ. А.Амар хэлмэгдүүлэлтийн эсрэг үйл ажиллагааг сөрсөн удирдагч, эсэргүүцэн тэмцэгч байжээ. Түүний ажил үйлс, хэлсэн ярьсан олон зүйл үүнийг нотолно. А.Амар XX зууны явцад төрсөн манай төрийн нэрт зүтгэлтэн болон товойжээ. Хөшөө босгох нэг хэрэг. Амар судлалыг сайтар хөгжүүлж, нарийн чиглэлтэй хийх хэрэгтэй байна. Хэлмэгдүүлэлтийн эсрэг үйл ажиллагааг хүнд хэцүү нөхцөлд маш нууц явуулж байв. Амар тэргүүтэн Орос, Коминтерний зөвлөлгөөг зарим зүйл нь монголд тохирохгүй хэмээн сөрөг тайлбар өгч, удаа дараагийн уулзалтанд бүрэн тусгаар тогтносон БНУ-ын тухай асуудлыг тавьдаг байсан нь тусгай учир бий. Цагаан хаан 1912 оны өвлийн дунд сарын арван долооноо “Танай гадаад Монголыг хэрхэвч бээр туслан өмгөөлмүй... Хэрэв хэрэг учир бий аваас хэлсээр байтугай. (Үнэн. 1991.Х сар дугаар 134 (17988) Найрамдлын уран аргаар хятадтай хэлэлцүүлсүгэй хэмээн монголыг Ленинийхээр энхрийлдээ тэвэрч

гартаа авчээ. Энэ бол монголчуудын эрх ашигт илэрхий сөргүүлсэн их гүрний цадиггүй дээрэнгүй үг байлаа.

Эх оронч үндэсний үзэлтэй монгол зүтгэлтнүүд ойлгон сөрөг үйл ажиллагаагаа явуулсаар 1928 оны МАХН-ын VII их хурлаар баруунтан, хөрөнгөтний үзэлтэй эсрэг нэр хаяг зүүж бүрмөсөн бут цохигдон, хэт зүүнтэн нам, төр засгийн эрхийг авч хэтрүүлэг нугалаа завхрал газар авлаа. Зүүний завхрал 1932 оныг хүртэл үргэлжилж МАХН-ын Төв Хорооны бүгд хурлаар завхруулагчид болон зайлуулагдсан бөгөөд шинэ эргэлтийн бодлого тэргүүлж, үндэсний ардчилсан хувьсгалын чиглэл тогтов.

“Зүүнтэн” социализм, хамтрал, коммун гээчийг хүчдэн галзууруулж ардын дургүйцлийг хүчтэй хөдөлгөсөн юм.

1932 онд баруун дөрвөн аймагт гарсан бослого хөдөлгөөн түүний илрэл болон гарч эрхээ хасуулсан хуучин феодал, ноёд түшмэд, баячууд аллага, таллага хийж хүний зүрх сугалахдаа хүрч зэвсэглэсэн отрядууд ажиллаж байжээ. Энэ нь төр засгийн эсрэг гарсан нь тодорхой бөгөөд малчин ардууд дааж давшгүй алба, татвар дарамтыг үл тэсвэрлэн өрх, гэр айл аймгаараа хил давж дүрвэсэн нь үнэн бөгөөд нугалаа завхралтай шууд холбоотой. Хил давж нүүгсдийн эсрэг буудсаныг юу гэж ойлгох вэ. Төр засаг ардын хоорондын тэмцэл туйлдаа хүрсэний шинж.

Төр засаг малчдын хооронд гарсан хурц зөрчил тэмцэл. 1930-аад оны сүүлчээр “Их хомрого” болж хүмүүсийг үй олноор нь дайчлан баривчилж хөнөөж байлаа. 1939 оны IX сард Монголд оросын “Фриновскийн хороох ёстой” 115 хүний нэрийн цэс барьсан алуурчид ирж их аллага шуурхай хэрэгжжээ. Цуст аллага үргэлжилсээр сүсэгтэн олондоо дээдлэн шүтэгдсэн номын их хутагт нарыг дараалан хомрогolon хөнөөлөө. Хөрөнгө хураах нэрийдлээр феодал баян түшмэд 729 аж ахуйг хамран үнэн хэрэгтээ эдийн засгийн талаар оршин тогтнох үндсийг нь устгасан хэрэг бөгөөд сүм хийд жасын хөрөнгөнд халдаж бас зарим чинээлэг ардууд ч хэлмэгдлээ. Феодалын анги гэж оросыг дууриан устгах бодлого явуулж хэрэгжүүлсэн нь тодорхой. Ардын хувьсгалаас хойш ардууд улс төрийн эрх чөлөө (сонгууль) хэлбэр төдий санал өгч, алба татварт ямагт нэрвэгдсээр дайны дараа дааж давшгүй алба төлөвлөгөөт даалгавар гүйцэтгэгч болж хувиран, төлөвлөгөөт даалгавар биелүүлээгүй өрхийг ганцаарчлан шүүхэд өгч шоронд хорьдог арга нэмэгдлээ. Төлөвлөгөөт даалгавар биелүүлээгүй малчин ард нэдэртээ төрийн эсрэг этгээд болж хувирлаа. Гэмгүй хүн гэмтэн болох нь ердийн үзэгдэл боллоо. Нам, төрийн эсрэг этгээд, үндэсний үзэлтэн

гэгчийг зориуд бий болголоо. МАХН ямагт эсрэг этгээд, аль нэг төөрөгдөл гэгчийг зориудаар зохион байгуулж, монголын соёл нийгмийн хөгжлийн асуудлаар намын үзэл суртлыг зөв санаанаас шүүмжилсэн хүмүүсийг ийнхүү бусармаг болгон буруутгав. Нэг намын дэглэмийн үед улс төрийн шинэ нэр томъёо гарч шинэ эсрэг этгээд төөрөгдөл үндсэрхэх үзэлтэн хэмээн хэлмэгдүүлсээр үл итгэхийн агаар хурсаар байлаа.

Бүр 1950-иад оны эхээр нэр бүхий бүлэг хүн МАХН-ын Төв Хороонд санал бичиж түүндээ СССР-ээс гадна гадаад орнуудтай эдийн засаг, соёлын өргөн харилцаа нээх, монголчууд өөрсдөө бие даасан бодолтой болох нээлттэй эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх, үндэсний шинэ соёлоо хөгжүүлэх, соёлын өв уламжлалыг залгаж хүчтэй анхаарах шаардлага дэвшүүлсэн юм. 1950-иад оны дунд үеэр сэхээтний төөрөгдөл гэгчийг МАХН сэдэж санал зөрсөн эсрэг гэгдэх хүмүүсээ олж авсан хэрэг болов. Энэ үед Ш.Нацагдоржийн "Нууц товчоо"-ны оршилд XIII зууныг "Алтан үе" гэсэн Б.Ринчин, Ц.Дамдинсүрэн нарын "Өрнөд өмнөдөд зорчсон тэмдэглэл"-үүд монголын өвөрмөц соёл иргэншлийг дэлгэж тавьсан хийгээд Ш.Гаадамбын бух Гомбын тухай сонирхолтой өгүүллэгийг бас л үндсэрхэх үзэл болгон буруутгасан. Гэвч 1947 онд уйгаржин монголоор, 1954 онд криллээр хэвлэж, БНМАУ-ын түүх нэгэн боть гарлаа. Эд цөм зөрчил тэмцэл дунд болсон юм. МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо МАХН-ын түүхээ сурах бичгийн чанартай бүтээхээр оролдоод эцэст нь МАХН-ын товч түүх бичихээр болгожээ.

Хоёр системийн тэмцэл "хүйтэн дайн"-аар сүрдүүлэн үндсэрхэх үзлийг дарах, гадаад хүчин нөлөөллийн эсрэг хүчтэй тэмцэл явагдлаа. Гэвч Чингисийн мэндэлсэн нутагт сүрлэг хөшөө босгож чадлаа.

Чингисийн мэндэлсний ойд хүчтэй бэлтгэж эрдэм шинжилгээний бага хурлыг эхлээд их хурлуудын танхимд, дараа нь дуурь бүжгийн театрт олон түмнийг өргөн оролцуулах гэж тэмдэглэхээр оролдсон бөгөөд эцэст Улсын нийтийн номын сангийн 106-р жижиг танхимд хийсэн байна. Шат хонгил хүнээр дүүрэн байлаа.

Б.Ринчин, Ц.Дамдинсүрэн нар сонирхолтой үг хэлж олны анхаарал татав. Тус хуралд Оросын хоёр эрдэмтэн оролцлоо. Нэлээн дуулиантай болж өнгөрч билээ. Акад. Ш.Нацагдорж гол илтгэлээ хоёр хэлбэрээр бэлдэж таалагдсаныг нь тавьсан бололтой юм билээ. Нэрт эрдэмтэн Б.Ринчин, Ц.Дамдинсүрэн Монголын түүх соёл, Чингисийн тухай сонирхолтой зүйлс ярьсан билээ. Д.Төмөр-Очир энэ хэрэгт чухам

ямар байр суурьтай байсан нь эрхийг нь барьж, учгийг нь мэдэх гол хүний хувьд сонирхолтой санагддаг.

Чингис марк гаргасан боловч хураах шийдвэр гарч нэн даруй хэрэгжиж билээ. Тэр их зүйл одоо хаа байдаг юм бол. Шатаасан устгасан тухай мэдээ бий. Хэрэг явдал ийм учир нь олдохгүй бөөн будлиан болж, тэмцэл гээч явагджээ.

Пролетарийн интернационализм, Зөвлөлт-Монголын найрамдал социалист эх оронч социалист хамтын нөхөрлөлийн үзлээр хүмүүсийн толгойг цэнэглэх ухуулга, суртал нэвтрүүлгийн ажил давалгаалан шуургалж байв. Ер монгол орноо түүхээ, хэл соёлоо гэсэн эх оронч хүмүүсийг үндсэрхэх үзэлтэн болгон үзжээ.

1960-аад оны дундуур Л.Цэнд буруутан болж Лоохууз, Нямбуу, Сурмаажав нар гэгч намын эсрэг бүлэг үндсэрхэх үзэлтэн гэгчдийг бутцохих тэмцэл явагдлаа. Хайран сайхан шударга боловсон хүчин сэхээтэн олон жилжжр амьдралыг нь хохироосон намын удирдлагын арга хэмжээ байв. Ингээд зогсохгүй тэдний улыг шагайж тагнаж мэдээлэл нууцаар авч хянасаар хяхсаар байжээ. Үүний тодорхой баримт нотолгоо тэднийг төр засаг, хууль цагдаагийн нууц хяналтанд далдаас туршин, энд МАХН-ын байгууллага ерөнхийд нь гардан хянаж, Төв Хороондоо мэдээлдэг байжээ. Дархан хотын Намын Хорооны I нарийн бичгийн дарга С.Гомбосүрэн МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын Хянан шалгах хороонд явуулсан маш нууц нэртэй захидал юм. (Манай индэр 1991 №5) Лувсанравданд хэмээн нууцалсан баримтанд Дарханы музейн барилга байгууламж удааширч хойшилж орсон. Б.Төмөр-Очирийг тогтвор суурьшил муутай, машин хөлөглөн хөдөө явж найдваргүй хүмүүстэй уулзаж ярьж зөвлөлдөж явсан гэжээ. Д.Төмөр-Очирын нам төрийн бодлогын эсрэг яриа гэж Ю.Цэдэнбал, Лувсанравдан, Рагчаа, Пүрэвжав нарыг ихээхэн занаж шүүмжилдэг, Төв хороог орос хүүхнүүдээр дүүргэсэн хэмээсэн хууль дүрмийг олон удаа зөрчиж байсан тухай үндэсгүй зүйлсээ албан тушаалаар шат ахих мөртөө өндөр албан тушаал горьдсон хэнээрхэгчдийн нэр төр хөөсөн тал зассан матаас байлаа. Бас Дархан хотын намын хороо, НАХЯ-нд Дархан хотын нийгмийг аюулаас хамгаалах хэлтсийн дарга хурандаа Ш.Дашдорж гэгч бас л нэр төр хөөж, алба ахихыг цаанаа агуулсан танилцуулга гэгчийг өргөжээ. (Манай индэр. 1991.№5) Тэрээр Д.Төмөр-Очирыг маш их хартай, Самбуу, Лоохууз, Цэрэнхүү, Лхамсүрэн, Дамдинсүрэн, Гаадамба нартай удаа дараа уулзаж учирч, хонуулж, өнжүүлж, тэд нь зорьж ирсэнийг хэд хоносон, өдөр судартай нь тоочжээ. Түүний үг яриа нь "Үйлдвэр, аж ахуй, соёл үйлчилгээг удирдах

арга муудаж бие биенээ зулгуйдах байдалтай болж муудсан. “Бидний одоогийн удирдагч нар уучилж өршөөхөөс өнгөрсөн, арга замыг олж тэмцэх хэлбэрийн үг” гэжээ. Манай ололт амжилтуудыг улам муудан доройтож байгаа мэтээр ярьдаг гэжээ. Ном их уншдаг архи их уудаг гээд аж амьдралаа тоочин 3 өрөө байшинтай сард 1350 төгрөг орчим цалин авдаг хэмээжээ. Дархан хотын барилга угсралтын конторын дарга Лхагваа гэгчтэй их дотносон байгаа гэх мэт. Энэ баримтуудыг чухам хаанаас авсан нь мэдэгддэггүй нь сонирхолтой, бодоход Д.Төмөр-Очирыг мөшгөгч, Ш.Дашдоржийн тусгай тэмдэглэл байсан байж болох юм. 1962 оны 1 сарын 25-27, 29-нд хуралдсан МАХН-ын Төв Хорооны II бүгд хурал дээр Д.Төмөр-Очир дэлгэрэнгүй үг хэлж (Үнэн 1991. №152) Чойбалсан, Цэдэнбал тэргүүтэй нам засгийн удирдагчдын ажил үйлсийн дутагдлыг хурц баримтан дээр шүүмжилжээ. Хэлсэн үгэндээ Д.Төмөр-Очир өөрийн үзэл бодол, чиг шугамаа дэвшүүлсэн бөгөөд гэмтэн, буруутан болсон үедээ ч хатуу баримталж байсан нь дээрх мэдээлэл гэгчээс ч тодорхой харагдана.

Д.Төмөр-Очирын бүгд хурал дээр хэлсэн хурц шүүмжлэл нь тухайн монголын олон нийгмийн шударга үзэл санааны цэгцтэй цогтой илэрхийлэл болсон гэж үзнэ. Бас нам төр засгийн нэг хүнийг тахин шүтэх, хүнд суртал, хоцрогдлыг халж өөрчлөх хурц санал байлаа.

Түүний хэлсэн үгэнд эргэж харах зүйлүүд байвч дүн тоймоороо өөрөө зоримог улс төрийн тэмцлийн хурц гараа байжээ гэж үзэх үндэслэлтэй.

Abstract: The article portrays the struggle of Mongolian herders, as well as other social groups, against the policies of ultra-leftist Communist party and government, and analyses the aftermath of such class-based policies.